



**БУЛГАН АЙМАГ
САЙХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

- 2015 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1102

Их хүрэмт

Г Болзол, журам, удирдамж батлах тухай Г

2014 оны сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 8 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ашиг сонирхлоос ангид төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэсэн төрийн албан хаагчийг шалгаруулах болзлыг 1, ЗДТГ-ын үйл ажиллагаа болон өөрийн хариуцсан ажлаа иргэд олон нийтэд тайлагнах журмыг 2, ажиллах сургалтын удирдамжийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Болзол, журам, удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн оролцоотой ил тод нээлттэй шинэлэг ажил зохион байгуулахыг ЗДТГ-ын төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний нийт албан хаагч нарт даалгасугай.

Гурав. Энэхүү болзол, журам, удирдамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа хариуцсан мэргэжилтэн /Н.Юмчинрагчаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С. ЛУВСАНЦООДОЛ
ГЗАС003